



МОНГОЛ УЛСЫН  
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх нэгж  
байгуулах тухай

“Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 247 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тухай хуулийн 4.1.13, 17.3, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг 2015 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс байгуулж, төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирлаар Х.Бадамсүрэнг томилон ажиллуулсугай.

2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

3. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2015-2016 онд хийх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны зардлын төсвийн төслийг боловсруулан 2015 оны 7 дугаар сард багтаан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг төсөл хэрэгжүүлэх нэгжийн захирал Х.Бадамсүрэнд үүрэг болгосугай.

САЙД



Д.ЭРДЭНЭБАТ



Аж үйлдвэрийн сайдын 2015 оны  
07 дугаар 21 өдрийн 137 тоот  
тушаалын Хавсралт

ТТТ3069 - 5913276

Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл  
хэрэгжүүлэх нэгжийн орон тоо

№	Албан тушаал	Тоо
1	Төслийн удирдагч-захирал	1
2	Техник, технологийн асуудал хариуцсан менежер	1
3	Төслийн эдийн засагч-хөрөнгө оруулалт, зах зээлийн судалгаа хариуцсан менежер	1
4	Дэд бүтэц, байгаль орчин, бүс нутгийн асуудал хариуцсан менежер	1
5	Жолооч	1
	<b>Нийт</b>	<b>5</b>